



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

АУДИТЫН КОМПАНИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дахь заалтын "и" хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийх компаниар "Мүүрь Аудит" (ХХ) компанийг сонгосугай.
2. Компанийн аудиторыг сонгож, "Мүүрь Аудит" (ХХ) компанитай аудитын гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан)-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ, ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны цэвэр ашгаас тус компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 108 төгрөгөөр тогтоож, 2023 оны цэвэр ашгаас 128,291,364 төгрөг хуваарилж, хүн амын орлогын албан татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу суутгасан дүнгээр 2024 оны 5 дугаар сарын 01-ний дотор мөнгөн хэлбэрээр олгосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй тус компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилж, тарааж олгох шийдвэрийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ХК) компанитай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан), ерөнхий нягтлан бодогч (Б.Сольрагчаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ